

ШИНЭ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХАНДЛАГА

С. Амартүвшин*

* МУБИС, МоСС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн ахлах багш, доктор

Түлхүүр үг: дижитал хувьсгал, даяар сүлжээ, шинэ хэрэгсэл, уламжлалт хэвлэлээс шинэ хэрэгсэл рүү шилжих үйл явц, шинэ хэрэгслийн дотоод тогтолцоо, цахим хэвлэл, цахим хувилбар, олон нийтийн сүлжээ, онлайн редакц, шинэ хэрэгслийн эрх зүйн орчин, иргэний болон оролцооны сэтгүүл зүй

Дижитал хувьсгал ба мэдээллийн харилцаа

Бид өнөөдөр мэдээллийн эрин үед амьдарч байна. Энэ эриний хамгийн том үйл явц бол “дижитал хувьсгал” бөгөөд энэхүү хувьсгал нь эрин үеийн сүүлийн шат¹ гэж судлаачид үзэх болов.

Энэ хувьсгал дижитал хөгжим, DVD тоглуулагч, телевиз, дижитал камер, зөөврийн компьютер, гар утас зэрэг төрөл бүрийн дижитал хэрэгслийн тусламжтайгаар амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд хамгийн хүчирхэг түрлэг нь “даяар сүлжээ” гэгддэг Интернетээр дамжин дэлхий дахинаа асар том “цунами” үүсгэн хүн төрөлхтний нийгмийн харилцааг орвонгоор нь өөрчилж байна.

Угтаа Интернетийн даяар сүлжээ дэлхийн сая сая хүний мэдээлэл олж авах, хүмүүс хоорондоо, хэсэг бүлэгтэй, олон нийттэй харилцах чухал хэрэгсэл болоод удаж байна². Өнөөдөр Интернетийг мэдээллийн шинэ хэрэгсэл гэдгийг хүлээн зөвшөөрөөд зогсохгүй, уламжлалт хэвлэлийн байрыг эзлэх орчин үеийн хүчирхэг хэрэгсэл хэмээн үзэх болжээ. Гэхдээ уламжлалт хэвлэлийг устгах бус, уусган нэгтгэх, зэрэгцэн орших хандлагатай болов гэдэгтэй бид санал нэг байна. Интернет дэлхийг хавтгай болгож, мэдээллийн харилцаанд шинэ шинэ хандлагуудыг авчирсан хүчирхэг хэрэгсэл төдийгүй, сэтгүүл зүйн бие даасан байдлыг үгүй хийж, нийгмийн харилцааны салшгүй хэсэг болгон өөрчиллөө. Шуудхан хэлэхэд сэтгүүл зүй бие даан оршихоо больж “олон нийтийн харилцаа”-ны нэг хэсэг нь болчихоод байна. Үүнийг уламжлалт болон шинэ мэдээллийн хэрэгслийн агуулгад гарсан сүүлийн үеийн шинэ шинэ олон үзэгдлээр тайлбарлаж болох ч бидний ярих асуудал биш тул энд хүрээд орхиё. Харин шинэ мэдээллийн хэрэгслийн талаарх яриандаа шууд орёё.

Ийм шинэ хэрэгсэл Монголд хэрхэн үүсч хөгжсөн байдлыг авч үзье.

Мэдээллийн шинэ хэрэгсэл Монголд нэвтрээд 20-иод жилийн нүүр үзэж байна. Бусад хэрэгслийн хөгжилтэй харьцуулахад хөгжлийнхөө энэ асар богино хугацаанд хөгжил дэвшлийн дараах үе шатыг туулжээ.

Нэгд, шинэ хэрэгсэл Монголд нэвтэрсэн үе шат (1992-1996)

Монгол улс 1992-1994 онд цахилгаан холбоонд технологийн шинэчлэлт хийж, аналог системийг тоон технологиор солих шилэн кабелийн сүлжээ үүсэж, Монголд Интернет хөгжих таатай нөхцөл бүрдсэн нэг ёсны бэлтгэл үе байв. Ингээд 1994 онд Монгол улс Интернетэд холбогдож, Датаком компани 1996 онд Интернетийн сүлжээ оруулж ирснээр Монголын Интернетийн хөгжлийн суурь тавигдсан байна. Тодорхой хэлбэл 1996 оны 1-р сарын 17-нд Монгол Улсад Интернет холбогдсоныг албан ёсоор зарлажээ³.

Хоёрт, Интернет сэтгүүл зүй үүсэн хөгжиж, цахим хэвлэлтэй болсон үе шат (1996-2009)

Интернет бий болсон нь харилцааны олон талын эрс шинэчлэлтийг авч ирсэн бөгөөд энэ үед хамгийн гол нь Монголын сэтгүүл зүйн салбар цахим хэвлэлүүдтэй болж, Интернет сэтгүүл зүй хэмээх шинэ ойлголт ч бий болов.

Монголын анхны вэб сайт болох "Mongolia Online" 1996 оны 2 дугаар сараас эхлэн ажиллаж, мөн онд Монголын хамгийн том цахим сонин "E-mail Daily News" долоо хоногт таван удаа гардаг болжээ. Манай тогтмол хэвлэлүүдээс "Өнөөдөр" сонин 1996

онд анх цахим хувилбартай болж, дараа нь 1997 онд "Ардын эрх" сонин Интернетэд сайтаа байрлуулжээ.

Ийнхүү 1996 оноос анхны вэб сайт, цахим сонин гарч цахим хэвлэлийн эхлэл тавигдав. Тогтмол хэвлэлүүд цахим хувилбартай болж, Интернетэд сайтаа байрлуулж эхэлсэн үе байв. Хожим 2008 он гэхэд бараг бүх томоохон сонин, сэтгүүл байнгын ажиллагаатай сайттай болсон байна. Зарим радио телевиз онлайнаар нэвтрүүлгээ цацаж, онлайн радио, телевиз ч бий боллоо. Ийнхүү 1996-2008 оны хооронд цахим хэвлэлийн дотоод тогтолцоо бүрэлджээ.

Гуравт, уламжлалт хэвлэлээс цахим хэвлэл рүү шилжих шилжилтийн үе шат (2009 оноос хойш)

1990-2001 онд сонины, 2001 оноос радиогийн, 2004 оноос телевизийн, 2005 оноос сэтгүүлийн тоон өсөлтийн үе байсан бол 2008 оноос онлайн мэдээллийн хэрэгслүүд олноор бий болж, харин уламжлалт мэдээллийн хэрэгслийн тоо бага зэрэг буурсан байна⁴. Ингэж Монголын хэвлэл мэдээллийн зах зээлд 2008 оноос онлайн мэдээллийн хэрэгслүүдийн өсөлт, технологийн дэвшил, нийгмийн харилцааны арга хэлбэрүүд нөлөө үзүүлснээр сүүлийн жилүүдэд мэдээллийн шинэ хэрэгслийг хүчирхэгжүүлж, уламжлалт хэвлэлээс цахим хэвлэл рүү шилжих үйл явц эрчимжсэн байна.

Тухайлбал, Ю-түб, блог, фэйсбүүк, твиттер зэрэг Интернет түшиглэсэн харилцааны хэрэгслүүд бий болсон нь сэтгүүл зүйн хөгжилд шинэ хандлагуудыг бий болгож, шинэ хэрэгслийн хэрэглэгчдийг улам ихээр татах болжээ. Мөн шинэ технологийн дэвшил

болох ухаалаг гар утас, модем, iPad зэрэг хэрэгсэл зах зээлд нэвтэрч, хэдхэн жилийн дотор манай хэрэглэгчдийн энгийн хэрэглээ болж, тэднийг Интернет рүү хошуурахад хүчтэй нөлөө үзүүлсэн юм.

2009 оны хэвлэлийн зах зээлийн онцлох үзэгдэл нь өдөр тутмын сонинууд онлайнаар захиалга авч, цахим хэлбэрээр уншигчдын гарт өглөө бүр хүрч эхэлсэн явдал байв. Сүүлийн жилүүдэд вэб сайтууд олноор бий болж, төрөлжин хөгжих болов. Өнөөдөр вэб сайтын 10 мянга гаруй домайн нэрийн бүртгэгдсэнээс 160 гаруй вэб сайт тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр тогтмол үйл ажиллагаатай сайтууд нэгдэн, Монголын сайтуудын холбоо, Монголын сайтуудын ассоциаци гэх мэргэжлийн хоёр ч байгууллагаа үүсгэн байгуулаад байна.

Шинэ хэрэгслийн өнөөгийн байдал

Өнөөгийн байдлыг ярихдаа хэдэн гол онцлогийг тоймлон хэлэх нь зүйтэй болов уу.

Монголд мэдээллийн шинэ хэрэгсэл жил тутмын судалгаагаар хэрэглэгчид нь өсч, үйл ажиллагааны хүрээ нь улам бүр тэлж байна. Одоо Монгол улсын хэмжээнд 20 гаруй, Улаанбаатар хотод 50-иад, хөдөө орон нутагт 20-иод байгууллага Интернетийн үйлчилгээ үзүүлж байна. Монголын хүн амын 70 орчим хувь нь Интернет ашиглаж байна гэсэн судалгаа гарчээ. Хэрэглэгчийн тоог нарийн тогтоох боломжгүй бөгөөд өнөөдөр дурын газраас утасгүй холболтоор ухаалаг гар утас, нөүтбүүк, iPad зэрэг хэрэгсэл ашиглан хэчнээн хэрэглэгч чөлөөтэй хандаж байгааг бүртгэж хэлэх боломжгүй юм. Тэгвэл

хөдөө орон нутагт шилэн кабель тавигдаж, хотын гэр хорооллууд руу түгээлт нь олон хэлбэрээр тэлсээр байгаа Интернет үйлчилгээ хэрэглэгчдээ улам бүр нэмэгдүүлсээр байна. Өнөөдрийн байдлаар Монгол улсын 270 гаруй суманд шилэн кабель тавигдчихаад байгаа нь шинэ мэдээллийн хэрэгсэл улс орон даяар хэрэглэгчдэд хүрэх гарц бүрэн нээгдээд байгаагийн нотолгоо юм. Гол нь 2016 он гэхэд Монгол улсын бүх сум Интернетэд холбогдоно гэсэн төлөвлөгөө байна. Тэр цагт "аалзны тор" (www.гэдэг утгаар — С.А.) Монголын дэлгэр уудам тал нутгийг бүхэлд нь хэрж, хэрэглэгчдийн тоо туйлдаа хүрнэ.

Ингэж хурдацтай хөгжиж буй мэдээллийн шинэ хэрэгслийг дагаад Интернет сэтгүүл зүйн хөгжил ч эрчимжиж, электрон хэвлэлийн өөрийн гэх дотоод бүтэц тогтолцоо бүрэлджээ. Өнөөдөр мэдээллийн шинэ хэрэгслийн дотор монгол хэлээр хэвлэн нийтэлдэг 160 гаруй сайт, 20 гаруй цахим сонин, сэтгүүл гарч байна. Томоохонд тооцогддог 30 гаруй сонин цахим хувилбартай болжээ. Мэдээж "сүлжээний сэтгүүл"⁵ гэгддэг блог асар олон болсныг энд нэмж хэлэх хэрэгтэй. Мөн 30 гаруй телевизийг Интернетээр үзэх боломжтой бол 10-аад радиог Интернетээр сонсох болж, бүр онлайн радио телевизийн анхны оролдлогууд ч хийгдэн, нэг ёсны цахим теле- болон радио сувгууд эх сууриа тавьжээ. Түүгээр ч зогсохгүй шинэ хэрэгсэл дэх Интернет сэтгүүл зүйн дэд бүтцийг бүрдүүлэх мэргэжлийн байгууллагууд бий болж байгаагийн хамгийн тод жишээ бол дээр дурдсан Монголын сайтуудын холбоо, Монголын сайтуудын ассоциаци юм.

Шинэ хэрэгсэл уламжлалт хэвлэлийн зах зээлд нөлөөлж, түүгээр ч барахгүй тэдгээрийг уусган нэгтгэх, зэрэгцэн орших шинэ үйл явц ажиглагдаж эхэллээ. Тухайлбал томоохон тогтмол хэвлэлүүд онлайн хувилбартай болсноор заримынх нь захиалга өсөх хандлага ажиглагдаж байна. Жишээ нь “Өдрийн сонин” 2009 оноос цахим хэлбэрээр захиалга явуулах болсноор жил бүр цахим сониных нь захиалга эрчимтэй өсч байгаа аж. 2009 онд 125 захиалагчтай эхэлсэн цахим хувилбарын захиалга нь 2010 онд 968, 2011 онд 2114, 2012 онд 3300 болтлоо өсчээ. Уншигчид хэвлэлийн онлайн хувилбарыг захиалаад зогсохгүй цахим сониныг нь ихээр уншиж байна.

Тухайлбал news.mn сайт 100000 хол давсан хандалтаараа тэргүүлдэг бол “Өнөөдөр” сонины вэб сайт (mongolnews.mn) өдөрт тогтмол 30000–40000 хандалттай байна. Интернетийн гол хэрэгсэл болох мэдээллийн сайтууд өдөрт дунджаар 15000–30000 хандалттай байдаг нь түүний хэрэглээ хэр өндөр болохыг харуулж байна.

Мөн мэдээллийн сайтуудын үйл ажиллагаа эрчимжихэд сонгуультай холбоотой бас нэг парадокс нөлөө эергээр нөлөөлснийг хэлэхгүй өнгөрч болохгүй. Сонгуулийн тухай хуулиар уламжлалт хэвлэлээр хийх сурталчилгааг хязгаарласан нь мэдээллийн сайтуудад энэ боломжийг ашиглан сонгуулийн хязгааргүй ил далд суртал-

чилгаагаар асар их ашиг орлого олох үүд хаалга нээгдсэн юм. Сайтууд тэрхүү орлогоороо багагүй хуримтлал бий болгоод зогсохгүй, нэгэнт ирж буй гэрэлт ирээдүй нь санхүүгийн бэрхшээлд санаа зовох асуудлыг арилгаж, зарлага бага ашиг ихтэй хэвлэлийн бизнесийн шинэ зах зээл хөгжиж эхэллээ.

Шинэ мэдээллийн хэрэгслийн редакц, мэргэжилтнүүдийн тухай шинэ шинэ ойлголтууд ч бий болов. Үүний хамгийн тод жишээ бол онлайн редакц, түүнд ажиллагсад, мэргэжилтнүүдийн тухай ойлголт юм.

Онлайн редакц буюу товчхондоо уламжлалт хэвлэлийн редакц шиг нэг оффист цуглаад ажиллах (оффлайн)

биш, гагцхүү сүлжээгээр хаанаас ч нэгдээд (онлайн) ажиллаад байх шинэ хэрэгслийн орчин үеийн редакциудын эх тавигдаад байна. Судлаачид угтаа онлайн сэтгүүл зүйн орчныг нэг том мэдээллийн редакц гэж үзэх болсон бөгөөд түүнд мэдээлэл материалаа байршуулж байгаа хэн бүхнийг тэр редакцийн онлайн ажилтан гэж үзэх болжээ.

Гэхдээ тэр нүсэр том редакци дотор бие даасан олон редакц оршиж, төрөл бүрийн портал болон вэб сайт, блог зэргээр үйл ажиллагаа явуулах болов. Тэднийг домайн вэб хаягаар нь л ялгачихаж болно. Манайд өнөөдөр өдөрт хэчнээн шинэ онлайн редакц үүсч байгааг тооцоолох аргагүй юм.

«
*Шинэ хэрэгсэл уламжлалт
хэвлэлийн зах зээлд нөлөөлж,
түүгээр ч барахгүй тэдгээрийг
уусган нэгтгэх, зэрэгцэн орших
шинэ үйл явц ажиглагдаж
эхэллээ. Тухайлбал томоохон
тогтмол хэвлэлүүд онлайн
хувилбартай болсноор
заримынх нь захиалга өсөх
хандлага ажиглагдаж байна.*
»

Ер нь онлайн редакцийг редактор, медиамен хоёр л зохион байгуулаад аваад явчихаж болдог байна (www.mongolnews.mn сайтыг гэхэд л хоёр программист хариуцаж байна). Гэхдээ өсөн нэмэгдэж байгаа хөгжлийг дагаад онлайн хэвлэлийн ажилтан (mediaman) нь бүр төрөлжин мэргэших хандлага ч тогтлоо. Тодруулбал, медиамен болох мэдээллийг ангилагч, хуулбарлагч, дахин боловсруулагч үүрэг бүхий шинэ мэргэжилтнүүд бий болж байна. Тэд «...үйл явдал, баримт асуудлыг сурвалжилдаг, эх сурвалжийг үндэслэн мэдээллийг "бүтээдэг", сэтгүүлчийн бус, харин мэдээллийн сан нөөцийг бүрдүүлэгч, эрэмбэлэгч, ангилагч үүрэг бүхий мэргэжилтэн»⁶ юм.

Томоохон сайтууд мэргэжлийн сэтгүүлчдийн зэрэгцээ блог, Twitter, Facebook зэрэг олон нийтийн сүлжээний хэрэгслүүдийг өөрсдийн хуудсанд холбох болсноор жирийн иргэдийг хамруулсан сайн дурын олон тооны "сурвалжлагч" (многочисленность "корреспондентов")⁷-тай online редакц болон хувирч байна.

Шинэ хэрэгсэл өнөөдөр Монголын иргэний сэтгүүл зүйн хамгийн шинэлэг бөгөөд ил тод чөлөөт индэр болж хувирлаа. Энэ утгаараа Интернет Монголын иргэний сэтгүүл зүйн хөгжилд шинэ өөдрөг ирээдүйг авч ирэв. Манай цахим хэвлэлүүд өнөөдөр блог, нийгмийн сүлжээний хэлбэрүүд, хувь хүний сайт зэргийг үйл ажиллагаандаа татан оролцуулж иргэн, хувь хүний оролцоог илт өсгөж, иргэний сэтгүүл зүйг ихээр дэмжих боллоо. Нөгөө талаас иргэд ч блог, фэйсбүүк хуудсуудаараа дамжин онлайн мэдээллийн үйл ажиллагаанд шууд оролцож, нэг ёсны оролцооны

сэтгүүл зүй (participatory journalism) эрчтэй хөгжиж байна.

Цахим ертөнц өнөөдөр хэвлэн нийтлэх чөлөөт талбар болж уламжлалт хэвлэл мэдээллийн сэтгүүлчдийг ч бичвэр нийтлэлээ шинэ хэрэгсэлд байрлуулж, брэнд бий болгох хандлага ажиглагдаж байна⁸. Интернет өнөөдөр энэ утгаараа сэтгүүлчдийн ямар нэг редакц, хэвлэлийн байгууллагаас хараат бусаар чөлөөтэй хэвлэн нийтлэх талбар болсон байна.

Өнөөгийн тулгамдсан асуудлууд

Аливаа хөгжил ямагт дардан байдаггүй, ямарваа нэг шалгуур саад бэрхшээлийг даван туулах болдог нь жам юм. Шинэ мэдээллийн хэрэгсэлд өнөөдөр Монголын нөхцөлд хоёр гол асуудал тулгамдаад байна.

Нэгд, хууль эрх зүйн орчны шинэчлэлийн асуудал маргаан үүсгэж байна.

Шинэ мэдээллийн хэрэгсэлтэй шууд холбоотой эрх зүйн зохицуулалтын шинжтэй хоёр баримт бичиг одоогоор гараад байна.

1. Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага

2. Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журам

Гэтэл энэ хоёр баримт бичиг нь зөрчил маргаан дагуулсаар байна. Гол нь ёс бус үйлдэл хандлагыг арилгах зорилготой гэх сэтгэгдлийг зохицуулах оролдлого, IP хаягийг ил болгох гэсэн нь эсрэгээрээ хүний үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг хязгаарласан, цаашлаад иргэдийг цагдан хянах гэсэн төрийн далд сонирхол дагуулж байна гэсэн шүүмжлэлд өртсөөр байна. Харамсалтай нь

шүүмжлэгчдийн хэлээд байгаа "иргэдийн аюулгүй байдал, эрх чөлөөнд халтай болох, улмаар сэтгэгдлийн хариуцлагыг вэб сайтууд хүлээх учир иргэний аюулгүй байдлын хариуцлагыг давхар үүрч, эх сурвалжаа илчлэх, чөлөөтэй үг хэлэх эрх чөлөөг хаан боогдуулах олон сөрөг үр дагаврыг авчрах" эрсдэл бодит зүйл болчихоод байна.

Хоёр дахь тулгамдсан асуудал нь, хэвлэлийн эрх чөлөө, хараат бус байдал алдагдаж байна.

Энд нэгд, сэтгэгдлийг зохицуулах нэрийдлээр хэвлэлийн эрх чөлөө, цаашлаад иргэний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх үндсэн эрхэд халдан дараах заалтуудыг шууд зөрчих боллоо. 2013 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр хуралдсан Засгийн газрын хуралдаанаар "Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем"-ийн тухай тогтоол гаргасан. Ингээд 4 дүгээр сараас Сэтгэгдлийн нэгдсэн систем ажиллуулж эхэллээ. Уг нь шинэ хэрэгсэл хөгжснөөр иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө бодит үзэгдэл болж, ХМХ-үүд ил тод байдал, олон ургальч үзлийн индэр болох өргөн боломж нээгдээд байсан юм.

Хоёрт, сайтуудыг албан ёсоор бүртгүүлэхийг шаардах боллоо. Тухайлбал, Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны болон Монголын Сайтуудын Ассоциацийн "Хамтран ажиллах санамж бичиг"-т заасан байна.

Монголд Интернетийг ялангуяа, сайтуудыг мэдээллийн хэрэгсэл хэмээн бүртгэх хууль эрх зүйн үндэслэл хараахан байхгүй байна. Ингэж бүртгэх ч утгагүй зүйл юм. Ялангуяа НҮБ-ын Үзэл санааны тусгай илтгэгчийн 2005

онд гаргасан Хамтарсан тунхаглалд "Интернет үйлчилгээний нийлүүлэлт, цахим хуудас, блог буюу мэдээлэл түгээлтийн онлайн систем, түүнчлэн Интернет өргөн нэвтрүүлэг ажиллуулахын тулд бүртгүүлэх, төрийн аливаа байгууллагаас зөвшөөрөл авах ёсгүй"⁹ гэж заасан байдаг.

Гуравт, өнөөдөр мэдээллийн сайтуудын 80 орчим хувь нь сүлжээний үйлчилгээ үзүүлдэг нэг л байгууллагад домайн нэрийн бүртгэлтэй байна. Энэ нь хараат бус байдалд сөргөөр нөлөөлнө. Товчхондоо үүгээр дамжин цагдан хяналт (цензур) тавих бүрэн боломжтой.

Цаашдын хандлага

- Дэлхий дахины сэтгүүл зүйн хөгжлийг тодорхойлж буй даяарчлал, эс олон нийтжилт, төвлөрөл, ижилсэх үйл явц манайд шинэ хэрэгслийн нөлөөн дор улам бүр эрчимжих хандлагатай байна.

- Монголд Интернет хэрэглээ ойрын үед эрчимжиж, түүнийг дагаад шинэ мэдээллийн хэрэгслийн хэрэглээ хот хөдөө ялгалгүй улам бүр өсөн нэмэгдэх болно. Энэ бол уламжлалт хэвлэлүүдийг цахим мэдээлэлд шилжүүлж, уламжлалт хэвлэлээс цахим хэвлэлд шилжих үйл явц туйлдаа хүрэх нь зайлшгүй.

- Манай Интернет сэтгүүл зүйн салбарт ажиллагсдын мэргэжилтний талаарх шинэ ойлголтууд жинхэнэ утгаараа төлөвшиж, онлайн редакциуд бий болсноор шинэ хэрэгслийг түшиглэсэн "ирээдүйн сэтгүүл зүй" хөгжих цаг ойрхон ирээд байна.

- Ирээдүйн сэтгүүл зүй мэдээллийг дамжуулах төдий биш, хайлтын систем, эргэх холбоо, онлайн өвөрмөц

орчин дахь харилцааны шинэ хандлага, кибер ертөнцийн шинэ соёл тэргүүтнээр хүч түрсэн мэдээлэл харилцааны том талбар болж хувирах нь нэгэнт тодорхой болжээ. Дижитал хувьсгалын үр дүнд туйлдаа хүрэх харилцааны энэ шатанд бодит байдал, жинхэнэ бодит ертөнц гэж бидний эргэн тойрны үзэгдэх байдал бус, шинэ мэдээллийн хэрэгсэлд багтсан гипер текст юм гэсэн үзэл санаа энгийн үнэн болох болно.

Дүгнэлт

Эцэст нь дүгнэвэл, шинэ мэдээллийн хэрэгсэл Монголын сэтгүүл зүй дэх ОНМ-ийн нөлөө бүхий хүчирхэг хэрэгсэл болж, уламжлалт хэвлэл мэдээллийг цахим хэвлэлтэй нэгдэн хөгжих дэлхийн чиг хандлагыг нэвтрүүлж, улмаар дижитал хувьсгалын давалгаг нэвтрүүлэгч нэг гол суваг болж байна.

Шинэ мэдээллийн хэрэгслийн хөгжлийн 20-иодхон жилийн хугацаанд Монголд цахим хэвлэлийн зах зээл бий болж, Интернет мэдээллийн хэрэгслийн дотоод бүтэц тогтолцоо бүрэлдэж, үр дүнд нь цахим хэвлэлүүд улам бүр төрөлжин хөгжиж байна. Мэдээж хөгжилд асуудал тулгарч, зохиогчийн эрхийн асуудал хөндөгдөж, үзэл бодлын үл нийцэл, сэтгэгдэл зэргээс үүдэлтэй хууль журамд харшлах зөрчил үүсч, түүнийг зохицуулах гэсэн хатуу оролдлогууд гарах боллоо. Үүнийг дагаад шинэ мэдээллийн хэрэгсэлд хяналт тавих гэсэн зүй бус хандлага гарах болж, хэвлэлийн эрх чөлөө, иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн асуудал хөндөгдөж байна.

Ийнхүү шинэ мэдээллийн хэрэгсэл амжилт, асуудлаар дүүрэн түүхэн тодорхой үе шатыг туулсаар тууштай хөгжлийнхөө замд орох хандлага нэгэнт бүрдээд байна.

Ишлэл

- ¹ Vineet Kaul. 2012. The Digital Communications Revolution. Online Journal of Communication and Media Technologies // <http://www.ojcmr.net/articles/23/237.pdf>
- ² Зулькафиль М. 2012. Орчин үеийн олон нийтийн харилцааны онол, үзэл баримтлалын зарим асуудлын тухайд // «Сэтгүүл зүй» МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг, №13/380, 13-14 дэх тал.
- ³ Болд-Эрдэнэ Б. 2009. Интернет сэтгүүл зүй. УБ., 86 дахь тал.
- ⁴ 2010. Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр // Хэвлэлийн хүрээлэн. УБ., 4 дэх тал.
- ⁵ Болд-Эрдэнэ Б. 2009. Интернет сэтгүүл зүй. УБ., 92 дахь тал.
- ⁶ Болд-Эрдэнэ Б. 2012. Нийгмийн мэдээлэл харилцааны "хувьслын онол" // «Сэтгүүл зүй» МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг, №13/380, 31 дэх тал.
- ⁷ Вельф А. Удовлетворение социального влечения // "Коммерсантъ Деньги", №40 (697), 13.10.2008, <http://www.kommersant.ru/doc.aspx?DocsID=1038254>
- ⁸ 2010. Хэвлэл мэдээллийн хууль (цуврал гарын авлага). УБ., 97 дахь тал.
- ⁹ Интернетийн талаар гарсан хамтарсан тунхаглал // <http://likeit.mn/news/id/2064>

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ Б. 2009. Интернет сэтгүүл зүй. УБ.
2. Болд-Эрдэнэ Б. 2012. Нийгмийн мэдээлэл харилцааны "хувьслын онол" // «Сэтгүүл зүй» МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг, №13/380.
3. Зулькафиль М. 2012. Орчин үеийн олон нийтийн харилцааны онол, үзэл баримтлалын зарим асуудлын тухайд // «Сэтгүүл зүй» МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг, №13/380.

4. Интернетийн талаар гарсан хамтарсан тунхаглал // <http://likeit.mn/news/id/2064>
5. Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. Хэвлэлийн хүрээлэн, мониторинг. УБ., 2010.
6. 2010. Хэвлэл мэдээллийн хууль (цуврал гарын авлага). УБ.
7. 2001. Communication theory. Oxford university press.
8. Vineet Kaul. 2012. The Digital Communications Revolution. Online Journal of Communication and Media Technologies // <http://www.ojcm.net/articles/23/237.pdf>

Summary

Recently information era has "digital revolution". This revolution has the strong influence on society, mass communication. During 20 years of passing life cycle, New Media became as powerful Mass Media. Furthermore it can change the view of mass communication and journalism. It will be affected in evolution of Mongolian Press. Concurrence legislative atmosphere and control of government could make a negative effect on new media which is a problem of journalism.